



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/98

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд “Төрийн албан хаагчийн түрээсийн орон сууц барих ӨВАХУСЗДТГ/202101009” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Эрдэнэжаргал - Ерөнхий боловсролын сургуулийн багш

Нарийн бичгийн дарга: Д.Норов - 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч

Гишүүд: Нямдорж - Ерөнхий боловсролын сургуулийн багш

С.Гэрэлт-Од - Ерөнхий боловсролын сургуулийн багш

Т.Даваадорж - Иргэний төлөөлөл /зөвшилцснөөр/

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Норов)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ